



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 86

Ховд

Г Санаал уламжлах тухай Г

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах аймгийн Сонгуулийн хороог хавсралтад тусгасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар Сонгуулийн Ерөнхий хороонд уламжилсугай.
2. Аймгийн Сонгуулийн хорооны бүрэлдэхүүний анкет болон холбогдох материалыг бүрдүүлж Сонгуулийн Ерөнхий хороонд уламжлахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 82, 88, 2017 оны 97 дугаар тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.



ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2020 оны ... дугаар  
тогтоолын хавсралт

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

	Нэр, эцэг /эх/-ийн нэр	Нас, хүйс	Эрхэлж буй ажил, албан тушаал	Мэргэжил, боловсрол	Сонгуулийн хороонд эрхлэх ажил	Утасны дугаар	И-Мэйл хаяг
1	Батжаргал Сандагсүрэн	40, эр	Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга	Инженер, дээд	Дарга	99062123	sagii_b@yahoo.com
2	Лхамсүрэнгийн Батбаяр	57 эр	Аймгийн БОАЖГ-ын дарга	Багш, дээд	Гишүүн	99432145	Lkham.Batbayar@yahoo.com
3	Норовын Бөхболд	59 эр	Жаргалант сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн багш	Багш, дээд	Гишүүн	99431207	Ith_hovd@yahoo.com
4	Чойням Түмэндэмбэрэл	56, эр	Аймгийн БТСГ-ын албаны дарга	Багш, дээд	Гишүүн	99012506	Tumee19640128@Gmail.com
5	Дарьсүрэнгийн Чинбат	53 эр	Хар-Ус нуур орчмын УТХГН-ын хамгаалалтын захирагааны мэргэжилтэн	ЁАгрономич, дээд	Гишүүн	99029815	Chinbaad22@yahoo.com
6	Алтангэрэл Энхзаяа	40, эм	Аймгийн УЦУОША-ны дарга	Инженер, дээд	Гишүүн	99037017	Zaya_www1@yahoo.com
7	Баатаржавын Баярсүх	36, эр	Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, Дотоод аудитын хэлтсийн дарга	Багш, дээд	Гишүүн	99004317	Bayarsukh_b@yahoo.com
8	Тогтох Эрдэнэтүяа	37, эм	Аймгийн Нийтийн номын сангийн захирал	Нийгмийн ажилтан, дээд	Гишүүн	98000190	t.erenetuya11@gmail.com
9	Бат-Очир Баяртуяа	30, эм	Аймгийн ИТХ-ын Ажлын албаны ОНИХХ-ийн дарга	Улстэр судлаач, дээд	Гишүүн	99433070	Pumaar_4@yahoo.com

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2020 оны <sup>86</sup> дугаар  
тогтоолын хавсралт

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр, эцэг /эх/-ийн нэр	Нас, хүис	Эрхэлж буй ажил, албан тушаал	Мэргэжил, боловсрол	Сонгуулийн хороонд эрхлэх ажил	Утасны дугаар	И-Мэйл хаяг
1	Батжаргал Сандагсүрэн	40, эр	Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга	Инженер, дээд	Дарга	99062123	sagii_b@yahoo.com
2	Тогтох Эрдэнэтүяа	37, эм	Аймгийн Нийтийн номын сангийн захирал	Нийгмийн ажилтан, дээд	Нарийн бичгийн дарга	98000190	t.erdenetuya11@gmail.com
3	Бат-Очир Баяртуяа	30, эм	Аймгийн ИТХ-ын Ажлын албаны ОНИХХ-ийн дарга	Улстөр судлаач, дээд	Гишүүн	99433070	Pumaar_4@yahoo.com
4	Лхамсүрэнгийн Батбаяр	57, эр	Аймгийн БОАЖГ-ын дарга	Багш, дээд	Гишүүн	99432145	Lkham.Batbayar@yahoo.com
5	Баатаржавын Баярсүх	36, эр	Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, Дотоод аудитын хэлтсийн дарга	Багш, дээд	Гишүүн	99004317	Bayarsukh_b@yahoo.com
6	Чойням Түмэндэмбэрэл	56, эр	Аймгийн БТСГ-ын албаны дарга	Багш, дээд	Гишүүн	99012506	Tumee19640128@Gmail.com
7	Алтангэрэл Энхзаяа	40, эм	Аймгийн УЦУОША-ны дарга	Инженер, дээд	Гишүүн	99037017	Zaya-www1@yahoo.com
8	Норовын Бөхболд	59, эр	Жаргалант сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн багш	Багш, дээд	Гишүүн	99431207	Ith_hovd@yahoo.com
9	Дарьсүрэнгийн Чинбат	53 эр	Хар-Ус нуур орчмын УТХГН-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн	Агрономич, дээд	Гишүүн	99029815	Chinbaad22@yahoo.com
10	Оодгой Тунгалаг	45, эм	Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч	Багш, дээд		99437770	oodgoitungalag@gmail.com
11	Намсрай Сэрээнэндорж	52, эр	2 сургуулийн сургалтын менежер	Багш, дээд		99435297	sereenen5@yahoo.com



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 87

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлийн 21.4, Монгол улсын Сонгуулийн өрөнхий хорооны 2016 оны 17 дугаар тогтоол, Сонгуулийн Ерөнхий хороо, Үндэсний архивын газрын даргын хамтарсан 2008 оны 22/69 дүгээр тушаалаар батлагдсан “Сонгуулийн холбогдолтой баримт бичгийг эмхлэн цэгцлэх, архивд шилжүүлэх, хадгалах, ашиглах журам” -ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 2016 онд явагдсан Улсын Их Хурал болон орон нутгийн сонгууль, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудсыг устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баяртуяа – Аймгийн ИТХ-ын Ажлын албаны Олон нийт, иргэдтэй харилцах хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Баярсүх – Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, Дотоод аудитын хэлтсийн дарга

О.Очирбат - Аймгийн ИТХ-ын Ажлын албаны Олон нийт, иргэдтэй харилцах хэлтсийн мэргэжилтэн

Г.Цогбадрах – Аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн тасгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн ахмад

Нарийн бичгийн  
дарга:

С.Батдорж – Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч

2. Сонгуулийн саналын хуудсуудыг журмын дагуу акт, тэмдэглэл үйлдэн устгахыг Ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 88

Ховд

Г  
Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол Улсын “Гавьяат малчин”- аар

1. Өлзий Цэнд-Аюуш - Зэрэг сумын Гүвээ багийн малчин

Монгол Улсын “Хүний гавьяат эмч” -ээр

1. Дангаасүрэн Бямбаа - Ховд аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн тасгийн эрхлэгч эмч  
“Сүхбаатарын одон”-гоор

1. Дэлэг Гарий - Жаргалант сумын Буянт багийн  
өндөр настан  
“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Дагийжамц Оюунцэцэг - Ховд аймгийн Эрүүл мэндийн газрын  
эмнэлгийн тусlamжийн газрын дарга  
“Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Тангад Санжаа - Жаргалант сумын Алагтолгой багийн  
өндөр настан  
“Алтангадас одон”-гоор

1. Жаргал Ганхуяг - Ховд аймгийн БОЭТ-ийн мэс заслын  
тасгийн эрхлэгч эмч

- |                                 |  |
|---------------------------------|--|
| 2. Төрбат Халтар                | - Жаргалант сумын Хайрхан багийн<br>өндөр настан         |
| 3. Дэлэг Цэрэндуулам            | - Чандмань сумын Жаргалан багийн<br>өндөр настан         |
| 4. Шагж Чимэгцэцэг              | - Чандмань сумын Урд гол багийн<br>өндөр настан          |
| “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар |  |
| 1. Олзвой Бямбасүрэн            | - Алтай сумын ЕБС-ийн ахмад багш                         |
| 2. Хонгороо Түмэндэмбэрэл       | - Алтай сумын ЕБС-ийн дотуур<br>байрны жижүүр            |
| 3. Бадамхорлоо Ариунтуул        | - Алтай сумын ЕБС-ийн нярав                              |
| 4. Торчоо Бөхчүлүүн             | - Алтай сумын Бодонч багийн өндөр<br>настан              |
| 5. Цэвгээ Гансүх                | - Булган сумын Далт багийн өндөр<br>настан               |
| 6. Шарав Оюунчимэг              | - Ховд аймгийн БОЭТ-ийн клиник<br>биохими, бактериологич |
| 7. Осор Нямцэрэн                | - Жаргалант сумын Бугат багийн<br>өндөр настан           |
| 8. Бексолтан Хусанбай           | - Ховд сумын Рашаант багийн өндөр<br>настан              |
| 9. Мишиг Машбат                 | - Үенч сумын хүн эмнэлгийн статистик<br>бага эмч         |
| 10. Идэш Батхүү                 | - Үенч сумын хүн эмнэлгийн жолооч                        |
| 11. Бэгз Мөнхөө                 | - Чандмань сумын Урд гол багийн<br>өндөр настан          |
| 12. Лхагважав Гэрэлчимэг        | - Чандмань сумын ЕБС-ийн физикийн<br>багш                |
| 13. Дэлэгсамбуу Лхамсүрэн       | - Ховд аймгийн Чандмань сумын өндөр<br>настан            |
| 14. Чимэд Тогтох                | - Чандмань сумын Талын булаг багийн<br>өндөр настан      |
| 15. Лэгшид Янжмаа               | - Чандмань сумын Тахилт багийн<br>өндөр настан           |
| 16. Цэрэндорж Баатарчулун       | - Эрдэнэбүрэн сумын Хүн эмнэлгийн<br>дуудлагын жолооч    |

ХУРЛЫН ДАРГА Г.ПУРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 29

Ховд

“Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн  
одонгоор шагнуулахаар өргөн  
мэдүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 116 дугаар зарлигаар баталсан “Эхчүүдэд алдарт эх 1, 2 дугаар зэргийн одон шагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- Ховд аймгаас “Эхийн алдар” 1 дүгээр зэргийн одонгоор 41, “Эхийн алдар” 2 дугаар зэргийн одонгоор 344, бүгд 385 эхийг шагнуулахаар тодорхойлолт, материалыг Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.
- “Эхийн алдар” 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулах эхчүүдийн тодорхойлолтыг зохих журмын дагуу бүрдүүлж, Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 90

Ховд

Г  
Тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр,  
төвийг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Аймгийн ИТХ дахь намын бүлгүүд, аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ыг сонгох сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, тойрогт ногдох мандатын тоог хавсралтаар баталсугай.
2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо, Сонгуулийн тойрог байгуулсан болон тойрог тус бүрд ногдох мандатын тоог тогтоосон тухай мэдээллийг аймгийн Сонгуулийн хороонд хүргэж, нийтэд сурталчлахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга / Б.Сандагсүрэн/-д даалгасугай.



**АЙМГИЙН ИТХ-ЫГ СОНГОХ СОНГУУЛИЙН ТОЙРОГ,  
НУТАГ ДЭВСГЭР, ТӨВ, ТОЙРОГТ НОГДОХ МАНДАТЫН ТОО**

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Тойргийн төв	Тойрот ногдох мандатын тоо
1	Жаргалант сумын Алагтолгой баг	Жаргалант сум	1
2	Жаргалант сумын Баатархайрхан баг	Жаргалант сум	2
3	Жаргалант сумын Бичигт баг	Жаргалант сум	2
4	Жаргалант сумын Бугат баг	Жаргалант сум	2
5	Жаргалант сумын Буянт баг	Жаргалант сум	2
6	Жаргалант сумын Жаргалан баг	Жаргалант сум	1
7	Жаргалант сумын Магсаржав баг	Жаргалант сум	2
8	Жаргалант сумын Наран баг	Жаргалант сум	2
9	Жаргалант сумын Рашаант баг	Жаргалант сум	1
10	Жаргалант сумын Хайрхан баг	Жаргалант сум	1
11	Жаргалант сумын Тахилт баг	Жаргалант сум	1
12	Жаргалант сумын Цамбагарав баг	Жаргалант сум	2
Аймгийн төв			19
13	Алтай сум	Хөх өндөр баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
14	Булган сум	Бүрэнхайрхан баг. Сумын Засаг даргын Тамгын газар	3
15	Буянт сум	Норжинхайрхан баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
16	Дарви сум	Булган баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
17	Дөргөн сум	Сээр баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
18	Дуут сум	Босго баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
19	Зэрэг сум	Хөндлөн баг. Сумын Засаг даргын Тамгын газар	2
20	Манхан сум	Төгрөг гол баг. Сумын Засаг даргын Тамгын газар	2

21	Мөнххайрхан сум	Сэнхэр баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
22	Мөст сум	Улаантолгой баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
23	Мянгад сум	Баянхошуу баг. Сумын Засаг даргын Тамгын газар	2
24	Үенч сум	Хөх үзүүр баг. Сумын Засаг даргын Тамгын газар	2
25	Ховд сум	Дунд–Ус баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
26	Цэцэг сум	Цэцэг нуур баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
27	Чандмань сум	Урд гол баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
28	Эрдэнэбүрэн сум	Хар ус баг. Сумын Засаг даргын Тамгын газар	1
Тойрог нийт		28	
Мандат нийт			41



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 91

Ховд

Г Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “к”, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Ховд суврага” ОНӨААТҮГ-ын 2020 оны үйл ажиллагааны орлогын доод хязгаарыг 106 000 000 төгрөг /нэг зуун зургаан сая/, зарлагын дээд хязгаарыг 106 000 000 төгрөг /нэг зуун зургаан сая /, үүнээс цалингийн санг 80325000 төгрөг /наян сая гурван зуун хорин таван мянга/ байхаар тус тус баталсугай.

2. “Ховд суврага” ОНӨААТҮГ-ын 2020 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангилал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Т.Баярсайхан/-д, байгууллагын орлогыг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг “Ховд суврага” ОНӨААТҮГ-ын дарга /Х.Хатанбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

3. COVID-19 вирусийн халдварт дэгдэлтэй холбоотой аймаг орон нутгийн ОНӨААТҮГазруудын хэвийн үйл ажиллагаа доголдон орлого, төсөв төлөвлөгөө тасарч, Нийгмийн даатгалын шимтгэл, Татварын өр авлага нэмэгдэх нөхцөл байдал бий болсон тул зохих хууль журмын дагуу боломжит эх үүсвэрээс нэмэлт санхүүжилт шийдвэрлэн дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА *[Signature]* Г.ПУРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 22

Ховд

Г Төлөвлөгөө батлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "к", 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Мянган Угалзат" ОНӨААТҮГ-ын 2020 оны үйл ажиллагааны орлогын доод хязгаарыг 263 600 000 төгрөг /хоёр зуун жаран гурван сая зургаан зуун мянга/, зарлагын дээд хязгаарыг 262 793 400 төгрөг /хоёр зуун жаран хоёр сая долоон зуун ерэн гурван мянга дөрвөн зуу/, цалингийн санг 105 429 700 төгрөг /нэг зуун таван сая дөрвөн зуун хорин есөн мянга долоон зуу/, ашгийг 806,000 төгрөг /найман зуун зургаан мянга/ байхаар тус тус баталсугай.

2."Мянган Угалзат" ОНӨААТҮГ-ын 2020 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангилал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Бат-эрдэнэ/-д, байгууллагын орлогыг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг "Мянган Угалзат" ОНӨААТҮГ-ын дарга /Н.Ганбат/-д тус тус үүрэг болгосугай.

3.COVID-19 вирусийн халдварт дэгдэлтэй холбоотой аймаг орон нутгийн ОНӨААТҮГазруудын хэвийн үйл ажиллагаа доголдон орлого, төсөв төлөвлөгөө тасарч, Нийгмийн даатгалын шимтгэл, Татварын өр авлага нэмэгдэх нөхцөл байдал бий болсон тул зохих хууль журмын дагуу боломжит эх үүсвэрээс нэмэлт санхүүжилт шийдвэрлэн дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 23

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “к”, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “ШИМ-УС” ОНӨААТҮГ-ын 2020 оны үйл ажиллагааны орлогын доод хязгаарын 1 581 283 400 төгрөг /нэг тэрбум таван зуун наян нэгэн сая хоёр зуун наян гурван мянга дөрвөн зуу/, зарлагын дээд хязгаарыг 1 565 607 500 төгрөг /нэг тэрбум таван зуун жаран таван сая зургаан зуун долоон мянга таван зуу/, үүнээс цалингийн санг 721 987 400 төгрөг /долоон зуун хорин нэгэн сая есөн зуун наян долоон мянга дөрвөн зуу/ ашгийг 15 675 900 төгрөг /арван таван сая зургаан зуун далан таван мянга есөн зуу/ төгрөг байхаар тус тус баталсугай.

2. “ШИМ-УС” ОНӨААТҮГ-ын 2020 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангилал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /М.Ганзориг/-д, байгууллагын орлогыг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг “ШИМ-УС” ОНӨААТҮГ-ын дарга /Т.Баатарзориг/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 94

Ховд

Үндсэн хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд Дуут суманд хийгдсэн 4 нэр төрлийн хавсралтад тусгагдсан 1266577189 төгрөг /нэг тэрбум хоёр зуун жаран зургаан сая таван зуун далан долоон мянга нэг зуун наян ес/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг балансад бүртгэхийг Дуут сумын Соёлын төвийн эрхлэгч /Д.Одонтуяа/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, ашиглалтыг хариуцаж ажиллахыг Дуут сумын Соёлын төвийн эрхлэгч /Д.Одонтуяа/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПУРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны  
04 сарын 24-ны өдрийн 94 дугаар  
тогтоолын хавсралт



ДУУТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН БАЛАНСАД  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансад бүртгэх үнэ	Тайлбар
1	Дуут сумын Соёлын төвийн барилга	ш	1	1,101,371,469	1,101,371,469	
2	Уурын зуухны барилга	ш	1	100,000,000	100,000,000	
3	Хашаа	m2	1000	60,000	60,000,000	
4	Халаалтын зуух	ш	1	5,205,720	5,205,720	
<b>Нийт дүн</b>					<b>1,266,577,189</b>	
/нэг тэрбум хоёр зуун жаран зургаан сая таван зуун далан долоон мянга нэг зуун наян ес/						

.....оо.....



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 25

Ховд

Үндсэн хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хавсралтад тусгагдсан 62615000 төгрөг /жаран хоёр сая зургаан зуун арван таван мянга/-ийн худаг, багийн барилгын засварын ажил, “Хөшөөт хөгжил сан”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 350968859 төгрөг /гурван зуун тавин сая есөн зуун жаран найман мянга найман зуун тавин ес/-ийн зам, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө, хандиваар хийгдсэн 34500000 төгрөг /гучин дөрвөн сая таван зуун мянга/-ийн нийтийн эзэмшлийн хөрөнгө, нийт 448083930 төгрөг /дөрвөн зуун дөчин найман сая наян гурван мянга есөн зуун гуч/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг балансад бүртгэхийг Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Билэгт/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, ашиглалтыг хариуцаж ажиллахыг Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Билэгт/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны  
04 сарын 24 нь өдрийн ... дугаар  
тогтоолын хавсралт

ЦЭЦЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЛАНСАД БҮРТГЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/ төгрөгөөр /

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтан д орсон он сар	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Балансад бүртгэх үнэ	Тайлбар
Зам							
1	Бетонон зам /1.1км/	2019	км	1.1км	255,120,253	255,120,253	
2	Бетонон зам /Баруун лагерийн/	2019	м	200	49,623,271	49,623,271	
	ДҮН			2	304,743,524	304,743,524	
Хөшөө, нийтийн эзэмшил							
3	"Ард Аюуш" цогцолбор /Ховд хөшөөт хөгжил сан/	2019	ш	1	25,000,000	25,000,000	
4		2019	ш	1	34,500,000	34,500,000	
	ДҮН			2	59,500,000	59,500,000	
Байгууламж							
5	Ухаалаг худаг /Сумын төвд/	2019	ш	1	12,950,000	12,950,000	
6	Хажинга баг Хүрэнгийн худаг	2019	ш	1	17,765,000	17,765,000	Улсын төв
		2019	ш	1	17,900,000	17,900,000	ОНХС
	ДҮН			2	48,615,000	48,615,000	
Барилга /засвар/							
7	Баянгол багийн барилгын засвар	2019	мкв	1	8,000,000	8,000,000	
8	Баян-Овоо багийн барилгын засвар	2019	мкв	1	6,000,000	6,000,000	
	ДҮН			2	14,000,000	14,000,000	
Тоног төхөөрөмж, биет бус							
9	Цагдаагийн драгер	2019	мкв	1	2,921,506	2,921,506	
10	Сум хөгжүүлэх сангийн программ	2019	мкв	1	800,000	800,000	
	ДҮН			2	3,721,506	3,721,506	

Тавилга эд хогшил

11	Суурин компьютер	2019	ш	1	1,780,000	1,780,000	Хөшөөт багийн төв тохижуулах
12	Принтер	2019	ш	1	490,000	490,000	
13	Проектор	2019	ш	1	1,343,900	1,343,900	
14	Зурагт	2019	ш	1	1,200,000	1,200,000	
15	Зургийн аппарат	2019	ш	1	1,645,000	1,645,000	
16	Ажлын ширээ	2019	ш	2	400,000	800,000	
17	Үгтвар ширээ	2019	ш	1	750,000	750,000	
18	Сургалтын ширээ	2019	ш	6	95,000	570,000	
19	Сандал /	2019	ш	80	50,000	4,000,000	
20	Дугуйтай сандал	2019	ш	2	230,000	460,000	
21	Дарга сандал	2019	ш	1	270,000	270,000	
22	Ажлын шүүгээ	2019	ш	1	640,000	640,000	
23	Ханын тавиур	2019	ш	1	285,000	285,000	
24	Бүйдан	2019	ш	1	670,000	670,000	
25	Модон ор	2019	ш	1	300,000	300,000	
26	Самбар	2019	ш	1	400,000	400,000	
27	Гадна гэрэл	2019	ш	1	1,600,000	1,600,000	
28	Модем төхөөрөмж	2019	ш	1	300,000	300,000	
	ДҮН			104	12,448,900	17,503,900	
	<b>НИЙТ ДҮН</b>					<b>448,083,930</b>	
	/Дөрвөн зуун дөчин найман сая наян гурван мянга есөн зуун гуч/						

.....ооо.....